

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ
САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.12.01

Аймгийн Засаг даргын Боловсрол шинжлэх ухааны Сайдтай байгуулсан засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ

Боловсрол шинжлэх ухааны салбарт 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Боловсрол шинжлэх ухааны салбарт 2022 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээг 1 дүгээр хавсралтаар 24 шалгуур үзүүлэлт, Засаг даргын хүлээх үүргийг гэрээний 3 дахь хэсэгт 76 үүрэг, нийт 100 ажил арга хэмжээ тусгасан байна. Эхний хагас жилийн хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийхэд 82.1 хувьтай байсан ба явцын хяналт шинжилгээгээр хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар чиглэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар жилийн эцсийн байдлаар 93.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.


Гэрээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар зорилт тус бүрээр харуулбал:

№	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Шалгуур үзүүлэлт	24	91.25
2	Засаг даргын хүлээх үүрэг	76	94.8
3	Дүн	100	93

Хоёр.Тайлангийн хугацаанд дараах арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжсэн байна.

Үүнд:

1. БШУЯамнаас хэрэгжүүлж байгаа төсвийн хүрээний шинэчлэлийг эхлүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилд 18 сургуулийн 1-р ангийн 34 бүлгийн нийт 966 сурагчаас Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, элсэлтийн ерөнхий шалгалт, цэцэрлэг, сургуулийн багш нарын гүйцэтгэлийн үнэлгээ, сургалтын байгууллагын гүйцэтгэлтийн үнэлгээний 5 шалгалтыг тус тус амжилттай зохион байгуулж, аймгийн хэмжээнд ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр нийт багш нарын 12.25 хувь нь 1-р түвшин, 33.3 хувь 2-р, 54.4 хувь нь 3-р түвшинд шалгагдсан бөгөөд Боловсролын ерөнхий газраас зарласан зорилтот болон сонголтот сургалтын 111 модульд аймгийн ЕБС-ийн



багш нар 100 хувь Aplus.mn-ээр цахимаар хамрагдан онолын мэдлэг, арга зүйн технологийг сайжруулан амжилттай суралцаж байна.

2. БШУЯ, Боловсролын хүрээлэнгээс боловсруулан гаргасан **“ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж”**-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургууль бүр хоцрогдол арилгах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг 2021-2022 оны хичээлийн жилийн 1, 2-р улирал, 2022-2023 оны 1-р улирлаар тооцон ажиллав. БШУГ-аас **“ЕБС-ийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд цахим хэлбэрээр дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлын удирдамж”**-ийг батлан, 2021-2022 оны хичээлийн жилийн 9 сараас эхлэн аймгийн ЕБС-ийн 19 сургуулийг 3 бүс болгон 9 удаагийн сургалтын хоцрогдол арилгаж байгаа сайн туршлага, цахим хичээлийн чанар, зохион байгуулалтын талаар санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгуулсан нь сургууль, багш нарын хамтын ажиллагаа сайжрав. Аймгийн ЕБ-ын 19 сургуулийн 84 хувь буюу 16 сургуульд БШУГ-ын **“Зөвлөн туслах баг”**-ийн хоцрогдол арилгах зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, тайлангийн хурлаар хэрэгжилтийн байдлыг дүгнэн үзэхэд 84 хувийн гүйцэтгэлтэй байлаа. Мөн **“Сайн сургууль-Сайн багш”** арга хэмжээний хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилийн 9 сард 19 сургууль оношлох үнэлгээг зохион байгуулж, 11 сарын зөвлөн туслах ажлаар 532 багшийн хоцрогдол арилгаж байгаа ажлын үр дүнтэй танилцан, 19 сургууль тус бүрд зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллав.

БАТЛАВ
БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН
ДАРГА *Ц.УРАНЯМБА* Ц.УРАНЯМБА

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ЗӨВЛӨН ТУСЛАХ БАГИЙН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД АЖИЛЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг: Ажлын багийн үйл ажиллагааны зорилго

Сумын сургууль, цэцэрлэгийг үйл ажиллагаатай танилцаж, нарийвчлан судалгаж хийж, заавар зөвлөгөө өгөх, төрийн албан хаагчдыг ажлын байран дээр суугаа хөндөгдөн хууль, тогтоомж, журмуудын талаар мэдээлэл өгөх, орон нутгийн бодлого шийдвэр, БШУЯ, Боловсролын ерөнхий газрын үйл ажиллагааны зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, 2022 оны БШУС-ын гэрээний биелэлтийг хангахад сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг оны эхнээс чиглүүлэхэд үйл ажиллагааны зорилго оршино.

Хоёр: Зөвлөн туслах ажлын багийн ажиллах хугацаа, хамрах хүрээ, зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл

Зөвлөн туслах ажлын баг нь 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн нэг суманд ажлын 1-ээс доошгүй өдөр зарцуулан ажиллана. Энэхүү үйл ажиллагаанд сургуулийн удирдлагууд, багш, ажилчид сурагчид хамрагдана.

№	Чиглэл	Сар өдөр		Байрлах сургууль
		1-р чиглэл	2-р чиглэл	
1	Хулд	3 сарын 9		
2	Далгархангай	3 сарын 10		Далгархангай
3	Сайжир-Овоо	3 сарын 11		Сайжир-Овоо
4	Эрдэнэдалай	3 сарын 14		Эрдэнэдалай
5	Адавцаг	3 сарын 15		
6	Луус	3 сарын 17		
7	Өлзийт	3 сарын 18		Өлзийт
		3-р чиглэл		
8	Далгарцогт	3 сарын 28		
9	Дэрэн	3 сарын 29		Дэрэн
10	Цагаандалгар	3 сарын 30		
11	Говь-Утгаал	3 сарын 31		Говь-Утгаал
12	Банжаргалан	4 сарын 1		Банжаргалан
13	Өндөршил	4 сарын 21		
14	Гурвансайхан	4 сарын 22		Гурвансайхан
		3-р чиглэл		
15	Эрдминдалай	4 сарын 25		үдийн цай

3. Аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд боловсролын салбарын хүний нөөцийг бүрдүүлж, дутагдалтай багш нараар хангахад аймгаас дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн гэрээт оюутан, багш болон төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөнд санал оруулан ИТХ-аар батлуулж, 6 оюутан гэрээгээр, 1 багшид орон сууцны дэмжлэг нийт 28,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.



4. **“Хүүхэд, багш, эцэг эхийн харилцаа, эрүүл аюулгүй орчин”**, **“Сайн багш-Сайн сургууль”** хоёр төрлийн сэтгэл ханамжийн судалгааг 19 сургуулийн 6240 сурагч, 1938 эцэг эх, 353 дотуур байрын сурагч, нийт 8531 хүнээс асуулга судалгаа авч, түүний үр дүнг сургуулийн удирдлага, хүүхэд хамгааллын багт танилцуулан хэлэлцүүлж зөвлөгөө чиглэл өгч шаардлагатай 2 суманд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч томилж ажиллуулав.

5. Орон нутгийн төсвийн хөрөнгө, иргэд, байгууллагын хандив, тусламжаар ерөнхий боловсролд 320,2 сая, цэцэрлэгт 160,0 орчим нийт 380,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар биеийн тамир, багш болон хүүхэд хөгжлийн танхим, цэцэрлэгийн ёс заншлын өргөө, тоглоомын талбай, сургалтын гадна дотно тохижилт, мөн багш нарын амьдрах орчин нөхцөлийг сайжруулж багш нарын байрны засвар зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн нь тэдний ажиллах, хөгжих орчин нөхцөлийг дээшлүүлсэн ажил үйлчилгээ боллоо.

6. Аймгийн хэмжээний нийт 19 сургуулийн 52 хувь буюу 10 сургууль **“Багш хөгжлийн төв”**-ийг өмнөх жилүүдэд байгуулж, 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилд Өндөршил, Баянжаргалан сумын ЕБС-иуд **“Орон нутгийн хөгжлийн сан”**-гийн 82.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгээр **“Багш хөгжлийн төв”**-ийг шинээр байгуулсан нь багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлсэн хөрөнгө оруулалт болов.

7. БШУГ-ын даргаар “Цахим контент-2022” арга хэмжээний удирдамжийг боловсруулан батлуулж, тус арга хэмжээнд аймгийн 19 сургууль, 22 цэцэрлэг 100 хувийн ирцтэй оролцож, цэцэрлэгийн бүлгийн болон сургуулийн 632 мэргэжлийн багш нарын 33 хувь буюу 210 багш нар цахим контентыг баг, хамт олноороо бэлтгэн амжилттай оролцож эхний байруудад шалгарсан 48 цахим контентод арга технологийн сангийн гэрчилгээг олгон, цэцэрлэгийн болон ЕБС-ийн мэргэжлийн 422 багш нарт арга туршлагыг түгээн дэлгэрүүлж, харилцан туршлага солилцлоо. Аймгийн хэмжээнд 163 суралцагч цахим сургуульд амжилттай суралцан, 3 багш үндэсний хэмжээнд цахим сургуулийн сургагч багшаар бэлтгэгдэн сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэв.



8. Мэдлэ.мн платформд аймгийн 19 сургуулийн 29 багш бие даан болон багаараа 16 нэгжийн 122 цагийн ээлжит хичээлийн цахим контентийг боловсруулан байршуулж, 38 багш багаар хамтран 14 нэгжийн 120 цагийн ээлжит хичээлийг боловсруулах эрх авсан нь багш нарын багаар мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллах чадварт суралцаж байгаагийн үр дүн гэж үзэж байна.



9. Сургуулийн ном сурах бичиг, сургалтын орчин, төсөв санхүү, хүний нөөц, сурагчдын статистик мэдээ, Цэцэрлэгийн сургалтын орчин, ундны ус ариун цэврийн байгууламж, төсөв санхүү, хүний нөөц, хүүхдийн статистик мэдээ тайланг хугацаанд нь 100 хувь тайлагнасан. Статистик мэдээ захиргааны маягтаар 65 төрлийн мэдээг цаг хугацаанд гаргаж хүргэсэн байна.

10. Аймгийн хэмжээнд 2022 оны жилийн эцэст 15 нэгжийн 15 багш 9 чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, 667 сургалтаар 33523 суралцагчдад, нөлөөллийн 742 үйл ажиллагаанд 25922 иргэн оролцож нийт-59445 хүнд насан туршдаа суралцахуйн үйлчилгээ үзүүлсэн нь тэднийг мэдээллээр хангасан, насан туршийн суралцахуйг дэмжсэн арга хэмжээ болов.

Гурав. Гэрээний заалтуудын дутагдалтай хэрэгжсэн арга хэмжээ:

1. Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын хүний нөөцийг бүрдүүлэхэд орон нутагт төрийн захиргааны албанд ажиллах боловсон хүчин дутагдалтай байдлаас болж аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх болон шинжлэх ухаан, инновацийн чиглэлээр тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэхэд мэргэжилтний ур чадвар, хөрөнгө санхүү дутагдалтай байв.

2. Инноваци хариуцсан мэргэжилтэн байхгүйгээс ажил эзэнгүйдэж, шинээр орж ирж байгаа ажлын ахиц үр дүн муу байна. /төрийн албаны шалгалтад тэнцэж орж ирэх хүний тоо Дундговь аймагт маш цөөн байна. Нийт 74 хүнээс 14 хүн шалгалтад тэнцсэн байна. Ялангуяа багш мэргэжилтэй хүн төрийн албанд орж ирэхгүй байна./

3. Инновацид салбар хоорондын байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, энэ чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах шаардлага тулгарч байна.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилгын ажлуудын төсөл хасагдсанаас явц удаашралтай байна.

5. Багш нарын ашиглаж буй компьютер шаардлага хангахгүй болсон. 2022 онд хийгдсэн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын багш нарыг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

Дөрөв. Санал, дүгнэлт, зөвлөмж

Аймгийн Засаг даргын Боловсрол шинжлэх ухааны сайдтай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээгээр хүлээсэн үүргийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг 93.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3б хавсралтын дагуу оны эхэнд боловсруулан батлуулж хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг